

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 09 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 14.30 цагт эхэлж, 17.10 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 40 минут үргэлжлэв.

| 1 | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмын төслийн тухай | Гадаад харилцааны яамнаас оруулж ирсэн Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмын төслийг Зөвлөл дээр ярьсан санал, өгсөн зөвлөмжүүдийг тусгаснаар нь батлав. |
| 2 | Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын сонгон шалгаруулалт, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай | 1.Батсүхийн Батмөнх, Баясгалангийн Ганбат нарыг Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцөд бүртгэх, 2.Энэ тогтоолын 1 дүгээрт заасан иргэдээс Баясгалангийн Ганбатыг Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | Мэдээллийн “МОНЦАМЭ” агентлагийн нэгжийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай | Мэдээллийн “МОНЦАМЭ” агентлагийн Гадаад сурталчилгаа эрхэлсэн ерөнхий редакторын албан тушаалд Сүхбаатарын Алтанцэцэгийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Мэдээллийн “МОНЦАМЭ” агентлагийн дарга Т.Баасансүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 4 | Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Ө.Одгэрэлийн гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай | 1.Өлзийхутагийн Одгэрэлийг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Статистик, мэдээлэл, хяналт-шинжилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлсэн Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 193 дугаар тогтоолыг хүчин төгөлдөр хэвээр үлдээж, түүнийг хэрэгжүүлэх үүргийг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт өгөх нь зүйтэй гэж гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх, |

| | | |
|---|---|--|
| | | 2.Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт энэхүү тогтоолыг хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 5 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга асан Л.Амарсанааг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай | 2008-2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар томилогдон ажиллаж байсан Лувсандагвын Амарсанааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 6 | Хан-Уул дүүрэг, түүний харъяа зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан үзлэгийн дүнгийн дагуу хийгдсэн зарим асуудлын тухай | 2008 оны орон нутгийн сонгуулиар Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа Ц.Мөнхсүхийг тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 122 тоот тушаалаар Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн даргаар томилон ажиллуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байх тул Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 122 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 7 | Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг хэсэгчлэн зохион байгуулах тухай | Танилцуулав. |
| 8 | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн 2009 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээний тухай | <p>1.Салбар зөвлөлүүдээс жил, улиралд тайлан мэдээ ирүүлж байх нэгдсэн загварыг Зөвлөлийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Зөвлөлийн гишүүн Д.Батбаяр, Ажлын албаны дарга Ц.Самбалхүндэв нарт даалгаж, Ажлын хэсэг байгуулж, энэ асуудлыг Зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр,</p> <p>2.Монгол Улсын хэмжээний Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг орон тооны болгох, эсвэл нэмэгдэл урамшуулал олгох энэ асуудлыг судалж, Зөвлөлд танилцуулах үүргийг Зөвлөлийн гишүүн Б.Өнөбаатарт даалгах,</p> <p>3.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын сорил (тест)-ыг орон нутгийн захиалгаар Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссоос боловсруулан, тагнуулын албаар дамжуулан хүргүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэж байхыг комиссын дарга, Зөвлөлийн гишүүн Д.Батбаярт үүрэг болгох,</p> <p>4.Төрийн албаны үйл ажиллагаатай холбоотойгоор хуулиудын зарим заалт зөрчилдөж</p> |

| | | |
|----|---|--|
| | | <p>байгааг нэг мөр болгох асуудлыг ерөнхийд нь хариуцаж, үр дүнг нь Зөвлөлд танилцуулж, Салбар зөвлөлүүдэд мэдэгдэх үүргийг Зөвлөлийн гишүүн Б.Өнөбаатарт даалгах,</p> <p>5.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн мөрдүүлэх асуудлыг Зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхам, Ажлын албаны дарга Ц.Самбаллхүндэв нар хариуцах,</p> <p>6.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн эрх хэмжээг нэмэгдүүлж шийдвэр гарган хэрэгжүүлдэг болгох гэсэн асуудлыг Д.Батбаяр гишүүн хариуцаж, яг одоо эрх хэмжээ нэмэгдүүлэх гэдэг дээр юу яриад байна, хууль тогтоомжид нийцэх юм байгаа юм уу, үгүй юм уу, бас нэг талд нь багтаагаад төвийн эрх хэмжээ, салбарын эрх хэмжээнд ялгачихаар ийм зүйл байна уу, үгүй юу гэдгийг нь судлаад Зөвлөлд танилцуулахыг Зөвлөлийн гишүүн Д.Батбаярт тус тус даалгав.</p> |
| 9 | Төрийн албаны зөвлөлийн Лого-ны загварыг батлах тухай | <p>1.Төрийн албаны зөвлөлийн лого-г батлав.</p> <p>2.Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн бэлгэ тэмдгийг 1 дүгээр хавсралтаар, түүний тайлбарыг 2 дугаар хавсралтаар тус тус батлан мөрдүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 10 | Бусад асуудал: Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан ажиллуулах тухай | Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд олон нийттэй харилцах ажилтан авч ажиллуулахыг Ажлын албаны дарга Ц.Самбаллхүндэвт даалгав. |